



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



УХАТ-ЫН САЛБАРЫН
ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН
ТАНИЛЦУУЛГА

*Илтгэгч: Зохицуулах зөвлөлийн
Тусгай зөвшөөрлийн албаны
мэргэжилтэн Е.Нямсүрэн*

Агуулга:

- УХАТ-ЫН САЛБАРТ ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖ
- ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ
- УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЧИГ ҮҮРЭГ
- ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТЛАН, УХАТ-ЫН САЛБАРТ ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ ДҮРЭМ,
ЖУРАМ
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГАД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



**УХАТ-ЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГДЭЖ
БУЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ**




УХАТ-ЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ ХУУЛЬ

- АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ
- УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ
- ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ
- БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ
- ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬ
- СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ
ОРОН СУУЦНЫ БАЙШИНГИЙН ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ
- ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬ
- ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ



ХОЛБОГДОХ ХУУЛИУДЫН ЗОРИЛГО




АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО:

Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО:

Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО : /2016.02.05-ны өдрийн шинэчилсэн найруулга/

Барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



ХОЛБОГДОХ ХУУЛИУДЫН ЗОРИЛГО

УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО : /2012 он/




Усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО : /2016.02.04-ний өдрийн шинэчилсэн найруулга/

Хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО :

Орон сууцны талаарх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, орон сууц төлөвлөх, орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалтыг өөрчлөх болон орон сууц ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.




ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИУДЫН ЗОРИЛГО



ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО :

Нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино.



ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛГО :

Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.



ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ





ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

хуулиар тусгайлан эрх олгогдсон

захиргааны байгууллагаас



нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан

гадагш чиглэсэн

үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй

шийдвэр

Тус Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш ХЗДХЯ-ны ЗХХ-ний актын УНБ-д УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулахад шаардлагатай үндсэн дүрэм, журам, тогтоолуудыг боловсруулан, шинэчлэн баталж, тогтмол бүртгүүлж ирсэн.



ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ

62 дугаар зүйл. Захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авах

- 62.1.Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна.
- 62.2.Нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ.




ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ




62.3. Энэ хуулийн 62.2-т зааснаас гадна дараах хүрээнд хэлэлцүүлэг хийж болно:

- эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;
- эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд;
- тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
- тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.



62.4. Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:


- уулзалт, ярилцлага;
- өдөр тутмын сонин хэвлэлд төслийг нийтэлж санал авах;
- цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах;
- бусад.



ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ

67 дугаар зүйл. Захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох

- 67.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ.
- 67.2.Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ




ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

А.Монгол Улсын
хуулиуд

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль

Б.ХСУХАТАҮЗЗ-
ийн тогтоол

- Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын талаар баримтлах бодлого, чиглэл
- Хот, суурин газрын усны үйлчилгээний тарифын талаар баримтлах бодлого чиглэл





А | ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ



А.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

- 15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл:
- 15.14.5. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

**АЖ АХУЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬ**

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.
- 12.2. Тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 12.2.1-12.2.14 төрлүүдээр олгоно.



А.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНГИЛАЛ:



УБ болон хөдөө, орон нутгийн нийтийн аж ахуй, ус суваг ашиглалтын байгууллага /Хуулийн 12.2.1-12.2.14/




Орон сууц ашиглалт, засвар үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага /Хуулийн 12.2.4-12.2.8 /



Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага /Хуулийн 12.2.11/



Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ / Хуулийн 12.2.14 /



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД **/УИХ-аас гаргасан тогтоолууд/**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоол/



Төрөөс экологийн талаар баримтлах бодлого /УИХ-ын 1997 оны 107 дугаар тогтоол/

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол/

“Ус” үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 24 дугаар тогтоол/

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

“Ногоон хөгжлийн бодлого” /УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол/



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030

ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО БОЛОН
МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛ-2030



2016 оны 2-р сард
УИХ-н 19 дүгээр
тогтоолоор ТХҮБ-г
баталсан.

Засгийн газрын 2016 оны
249 дүгээр
тогтоолоор ТХҮБ-н журам
батлагдсан.

Богино болон
дунд хугацааны
бодлогыг ТХҮБ-
тай уялдуулах



МОНГОЛ УЛСЫН
АСГИЙН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 /УИХ-ЫН 2016 ОНЫ 19 ДУГААР ТОГТООЛ/

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Үе шат I: 2016-2020

Үе шат II: 2021-2025

Үе шат III: 2026-2030




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



Усны нөөцийн нэгдсэн менежмент

Зорилт 1.
Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх

Зорилт 2.
Ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Баталгаат ундны
усаар хангагдсан
хүн амын эзлэх
хувийг 80 хувьд
хүргэж, хүн амын
40 хувийг
сайжруулсан ариун
цэврийн
байгууламжтай
болгох.

Баталгаат ундны
усаар хангагдсан
хүн амын эзлэх
хувийг 85 хувьд
хүргэж, хүн амын
50 хувийг
сайжруулсан
ариун цэврийн
байгууламжтай
болгох.

Баталгаат ундны
усаар хангагдсан
хүн амын эзлэх
хувийг 90 хувьд
хүргэж, хүн амын
60 хувийг
сайжруулсан
ариун цэврийн
байгууламжтай
болгох.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

КРІ нь
Салбарын
үйлчилгээний
түвшинг
хянах,
харьцуулах

Тусгай зориулалтын салбарын цахилгаан хангамжийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээ

№	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хэмжээний нэгж	Тусгай зориулалтын салбарын цахилгаан хангамжийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээ		
			Нийт	Шар	Тусгай
1	Балалгат үндэс усгаар хангагдсан хүн амын хэмжээгээр (ТЭЗ-ийн үйлчилгээнд хамаарсан хүн амын хэмжээгээр)-судалгаа	%	100	100	100
2	Тээвэрлэлтийн түвшин	Орчим үзүүлэлт	%	100	100
		ХВ-ийн үзүүлэлт	%	100	100
3	Цахир урмын хангамжид хэргийн төлөлийн төлөв	%	100	100	100
4	Цахир урмын үйлчилгээний түвшин	Хийгүүр Бодис	%	100	100
		Хийгүүр Бодис - зардалгүй үйлчилгээний түвшин	%	100	100
		Хийгүүр Бодис - зардалгүй үйлчилгээний түвшин	%	100	100
5	Хийгүүр Бодис	%	100	100	
6	Хийгүүр Бодис	%	100	100	
7	Хийгүүр Бодис	%	100	100	
8	Цахир урмын үйлчилгээний түвшин	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100
		Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100
9	Орчим үзүүлэлт	Орчим үзүүлэлт	%	100	100
		Орчим үзүүлэлт	%	100	100
10	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100	
11	Цахир урмын үйлчилгээний түвшин	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100
		Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100
12	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100	
13	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100	
14	Цахир урмын үйлчилгээний түвшин	%	100	100	
Нийт дүн					

А. УБ хот болон аймгаар орон нутгийн УХАТ-ын шилжилт, үйлчилгээний аралын ТЭЗ-ийн үзүүлэлтүүд

АД	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Тодорхойлолт	Тооцоох аргачлал	Хяналт
1	Балалгат үндэс усгаар хангагдсан хүн амын хэмжээгээр (ТЭЗ-ийн үйлчилгээнд хамаарсан хүн амын хэмжээгээр)-судалгаа	Тусгай зориулалтын салбарын цахилгаан хангамжийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээгээр (ТЭЗ-ийн үйлчилгээнд хамаарсан хүн амын хэмжээгээр)-судалгаа	$R_{\text{Балалгат}} = \frac{N_{\text{Балалгат}}}{N_{\text{Хүн амын хэмжээгээр}}} \times 100\%$	Хяналт гаргах
2	Цахир урмын үйлчилгээний түвшин	Цахир урмын үйлчилгээний түвшин	$K_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}} = \frac{N_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}}}{N_{\text{Хүн амын хэмжээгээр}}} \times 100\%$	Хяналт гаргах
3	Тээвэрлэлтийн түвшин	Тээвэрлэлтийн түвшин	$K_{\text{Тээвэрлэлтийн түвшин}} = \frac{N_{\text{Тээвэрлэлтийн түвшин}}}{N_{\text{Хүн амын хэмжээгээр}}} \times 100\%$	Хяналт гаргах
4	Цахир урмын үйлчилгээний түвшин	Цахир урмын үйлчилгээний түвшин	$L_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}} = \frac{N_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}}}{N_{\text{Хүн амын хэмжээгээр}}} \times 100\%$	Хяналт гаргах
5	Цахир урмын үйлчилгээний түвшин	Цахир урмын үйлчилгээний түвшин	$M_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}} = \frac{N_{\text{Цахир урмын үйлчилгээний түвшин}}}{N_{\text{Хүн амын хэмжээгээр}}} \times 100\%$	Хяналт гаргах



ХУУЛИЙН ХҮРЭЭНД УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

ҮНЭ ТАРИФЫН ТАЛААР

- Нэгдсэн бодлого боловсруулах
- Зохистой бүтцийг тогтоох
- Зөрүүтэй байдлыг ойртуулах, тухайн орон нутагт нэг үнэ тариф мөрдүүлэх
- Бодит өртөг зардалтай нь уялдуулах, өртөг зардлыг хянах, хөндлөн татаасын бодлогыг хэрэгжүүлэх

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААР

- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох,
- Нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хангуулах (зөвшөөрөлгүй хуулийн этгээдийг илрүүлж, бүртгэлжүүлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог бий болгох)
- Үйлчилгээний чанарт хяналт тавих: Стандартын шаардлагад нийцсэн унд ахуйн усаар хангаж буй эсэх, засвар, үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэж буй эсэх, ЦБ-аас гарч буй ус стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавьж, зөрчлийг арилгуулах,
 - Мэдээллийн сан байгуулах

ЭРХ ЗҮЙН ТАЛААР

- Хуулийн зохицуулалт
- Аж ахуйн харилцааны дүрмийг батлах
- Техникийн нөхцөл олгох журмыг батлах
- Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулах



**Б | ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ЭРХ ЗҮЙН ОРЧИН ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ**



Б.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрлийн талаар баримтлах зохицуулалтын бодлого чиглэлийг олон нийтэд ил тод болгох зорилгоор боловсруулан, 2017.01.09-нд 17 тоот тогтоолоор шинэчлэн баталсан.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛ:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хуулийн этгээдэд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОТ, СУУРИН ГАЗРЫН УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ, ТАРИФЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ:

- Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд усны үйлчилгээний тариф, ТЗЭ-чдийн эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хэрэглэгч хангагчийн тэгш байдлыг хангах, ТЗЭ-чдийн үйл ажиллагааг тасралтгүй найдвартай явуулах нөхцлөлийг бүрдүүлэн, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхэд чиглэнэ.

Б.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ:

- Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг үнэлэх журам
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм
- Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн шугам, сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам

Б.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ:

- Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн байдал, тариф хянан шалгах дотоод журам
- Усны үйлчилгээний суурь хураамж тооцох заавар
- Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам
- Үйлдвэрлэл, үйлчилгээний бохир усны тариф тооцох аргачлал
- Холбогдох бусад заавар, зөвлөмжүүд

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТЛАН ГАРГАСАН ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ





ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН



**ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС БАТЛАН
ГАРГАСАН ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ,
ТЭДГЭЭРТ ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД**





Б.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГҮҮД

- Улсын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;
- Тухайн орон нутагт усны үйлчилгээний тариф тогтоох;
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифын аргачлалыг боловсруулж, батлах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон ТЗЭ хэрэглэгчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах,
- Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний мэдээллийн санг байгуулах,
- Аж ахуйн харилцааны дүрэм батлах,
- Техникийн нөхцөл олгох журам батлах.





ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Зохицуулах Зөвлөлөөс баталсан дүрэм, журмууд:

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага-2012.06.18

Хот, суурины ус хангамж ариутгах татуургийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам-2012.08.17

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар /1-р хавсралт/-2012.09.18

“Аж ахуйн харилцааны дүрэм”-ийг боловсруулан баталж, ХЗЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3410 дугаарт бүртгүүлсэн-2013.03.26

Ус олборлон цэвэршүүлэх үйл ажиллагаа эрхлэх ТЗ-ийн нөхцөл шаардлага /2-р хавсралт/-2013.07.09

“Ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгох журам”-ыг боловсруулан, баталж, ХЗЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн-2013.10.25



ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Зохицуулах Зөвлөлөөс баталсан дүрэм, журмууд:

Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээ, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт /KPI/-ийг үнэлэх аргачлал-2015.05.07

Хот, суурины УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх ТЗ-тэй байгууллагуудын бохир усны машинд хэрэглэх таних тэмдэг /лого/-ийн журам-2015.06.23

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хянах зорилгоор “Хяналтын хуудас” боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн-2016.08.04

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн баталж, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3674 дугаарт бүртгүүлсэн-2016.12.16

Зохицуулах зөвлөлөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, 17 тоот тогтоолоор баталсан-2017.01.09



ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Зохицуулах Зөвлөлөөс баталсан дүрэм, журмууд:

“Ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгох журам”-ыг шинэчлэн батлан, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3672 дугаарт бүртгүүлсэн-2016.11.11

Тусгай зөвшөөрөл олгох болон сунгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам-А/14 тоот тушаалаар-2017.04.27

Аж ахуйн харилцааны дүрмийг 2017.05.19-нд шинэчлэн 74 тоот тогтоолоор батлан, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3744 дугаарт бүртгүүлсэн-2017.05.19

ТЗЭ-ийн үйл ажиллагааг дүгнэх болон Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээний журам-А/02 тоот тушаалаар-2017.04.03

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулан, баталж, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3674-т нэмэлтээр бүртгүүлсэн-2018.01.19



ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Зохицуулах Зөвлөлөөс баталсан дүрэм, журмууд:

Усны үнэ тарифын тогтолцоог шинэчилж , суурь хураамжтай 2 талт тарифыг нэвтрүүлсэн 2014 он

Аймаг, орон нутаг болон Улаанбаатар хотын усны үйлчилгээний тарифыг тухай бүр хянаж батлан, шинэчилж, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

ТЗЭ байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж, зардалд нь хяналт тавьж үргүй зардлыг нь бууруулах чиглэлээр ажиллан БОш тогтоож ажиллаж байна.

Тарифын тогтолцоог шинэчлэхтэй холбогдуулан “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал”-ыг боловсруулан, 11 тоот тогтоолоор 2018.01.19-нд батлан, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлийн 3846 дугаарт 2018.01.31-нд бүртгүүлсэн.



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

*Тэгш,
Чанартай,
Найдвартай,
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд*

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ
БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ
НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ
2018.01.19**





ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ШИНЭЧЛЭХ БОЛСОН ШАЛТГААН:



- ❑ Тусгай зөвшөөрлийг сунгуулах байгууллагуудад тавих хяналтыг сайжруулж, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд ойртуулах,
- ❑ Унд-ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн болон чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангуулах,
- ❑ Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд “...хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болгошгүй этгээдэд... санал гаргах боломж олгоно.” заасан заалтыг хэрэгжүүлэх.





ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ


Өмнөх заалт:

2500 м³/хоногоос дээш хүчин чадалтай ус хангамжийн байгууламжийн хувьд усны шинжилгээний лабораторитой байх, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

Шинэчилсэн заалт:

300 м³/хоногоос дээш хүчин чадалтай ус хангамжийн байгууламжийн хувьд усны шинжилгээний лаборатори, **тухайн мэргэжлийн инженер, технологич, засварчинтай байх**, 300м³/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

Олборлосон усны хэмжээ





ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ

“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт. MNS 0900:2005” стандартын 5.1-д: *Унд болон ахуйн зориулалтаар ашиглах зөвшөөрөлтэй бүртгэгдсэн ус нь түүний эх үүсвэр, чанарыг сайжруулах арга, ус хангамжийн тогтолцооны онцлогоос үл хамааран усаар дамжин халдварт болон халдварт бус өвчин тархах аюулгүй, физикийн үзүүлэлт, химийн найрлагаараа зохимжтой, хоргүй, мэдрэгдэх чанар нь харшлахгүй байх нөхцлийг хангах ёстой*” гэж заасан байдаг. Иймд шинээр дараах заалтыг оруулж байна.

Ундны усыг халдваргүйжүүлж буй байдал



2.6.2 з. Хот, суурин газрын хүн амд ус хангамжийн эх үүсвэрээс унд, ахуйн зориулалтаар олборлон, дамжуулан түгээж буй ус нь ундны усны чанарын холбогдох стандартыг хангасан, халдваргүйжүүлсэн байх;





ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БОЛОН СУНГУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ

Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд “...хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болгошгүй этгээдэд... санал гаргах боломж олгоно.” заасан заалтыг хэрэгжүүлэх зорилгоор:

2.6.4-ын “и” Хэрэглэгчдээс үйлчилгээнийхээ талаар санал, хүсэлтийн судалгааг авч, дүгнэл гарган, холбогдох арга хэмжээг авсан байх.





ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

*Тэгш,
Чанартай,
Найдвартай,
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд*

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН
СУНГАХТАЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ
2017.04.27**




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАХТАЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

ЗОРИЛГО НЬ:

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгохтой холбоотой хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичиг, санал, хүсэлтийг хянах үйл ажиллагааг ил тод шуурхай, хариуцлагатай болгоход оршино.

Хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлтээ батлагдсан маягтын дагуу дараах үе шатаар гаргана.

Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах үйл ажиллагаа:



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАХТАЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаа:

ТЗ шинээр авах болон сунгуулах хүсэлтийг Зохицуулах зөвлөлийн ажлын алба хүлээн авч, баталгаажуулна.

ТЗ хүссэн материалыг хянах, баталгаажуулах явцад холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй тохиолдолд ажлын 10 хоногийн дотор хүсэлтийг албан тоотоор буцаана.

Хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлт, холбогдох материал нь шаардлага хангасан тохиолдолд газар дээр нь ТЗНШ хангаж буй эсэхийг хянан, үр дүнг Зохицуулах зөвлөлийн даргад танилцуулж, Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлүүлнэ.

Зөвлөлийн хурлаас хүсэлт гаргасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийг олгохгүйгээр шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэрийг албан тоотоор хүргүүлнэ.

Зохицуулах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэхээр төлөвлөгдсөн асуудлыг хуралдааны дэгийн дагуу танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Зөвлөлийн хурлаас хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах шийдвэр гаргасан тохиолдолд ажлын алба тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, гүйцэтгэлийн гэрээ байгуулна.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН СУНГАХТАЙ ХОЛБОГДСОН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

№	Баримт бичгийн нэр	Тайлбар
1	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	Хуулийн этгээд нь ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг эрхлэхдээ хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.
2	Хот,суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль	
3	“Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” Зохицуулах зөвлөлийн 2016 оны 98 тоот тогтоол	Тусгай зөвшөөрөл олгох эсэхэд баримталж буй үндсэн баримт бичиг болно. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг Зохицуулах зөвлөлийн 2012 оны 05 тоот тогтоолоор, 2013 оны 18 тоот тогтоолоор, 2014 оны 66 тоот тогтоолоор, 2016 оны 08 тоот тогтоолоор, 2016 оны 83 тоот тогтоолоор тус тус шинэчлэн баталж байсан. Одоогийн байдлаар тус Зохицуулах зөвлөлийн 2016 оны 98 тоот тогтоолоор шинэчлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗДХЯ-ны Сайдын 2016 оны А/222 дугаар тушаалаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3674 дугаарт бүртгүүлж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус Зохицуулах зөвлөл нь дараах хууль, дүрэм, журмуудыг үндэслэн хуулийн этгээдээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хянан, шийдвэрлэдэг.

**ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ
БОЛОН
СУНГАХТАЙ
ХОЛБОГДСОН
ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛАХ
ЖУРАМ**

№	Баримт бичгийн нэр	Тайлбар
4	Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээ, үйл ажиллагааг үнэлэх аргачлал батлах тухай Зохицуулах зөвлөлийн даргын 2015 оны А/18 тоот тушаал	Тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж байгууллага нь тус Зохицуулах зөвлөлтэй байгуулдаг гэрээнд зааснаар жил бүр тайлан мэдээгээ ирүүлэх бөгөөд ТЗ-ийг сунгахдаа тухайн байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэнд энэхүү аргачлалын дагуу үнэлгээ хийж, цаашид ТЗ-г сунгах асуудлыг шийдвэрлэнэ.
5	Хяналтын хуудас батлах тухай Зохицуулах зөвлөлийн даргын 2016 оны А/34 тоот тушаал	Хуулийн этгээдийн ТЗ авахаар ирүүлсэн хүсэлт, холбогдох материал нь шаардлага хангасан тохиолдолд газар дээр нь ТЗНШ хангаж буй эсэхийг хянан шалгахад энэхүү Хяналтын хуудасыг хэрэглэж, дүгнэлт гаргадаг.
6	Журам батлах тухай Зохицуулах зөвлөлийн даргын 2016 оны А/36 тоот тушаал	Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ээс дагаж мөрдөхтэй холбогдуулан “Сонсох ажиллагааны журам”-ыг Зохицуулан зөвлөл нь батлан гаргаж мөрдөж байна. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг шийдвэрлэхэд сонсох ажиллагааг зохион байгуулна.
7	Хүснэгтийн загвар батлах тухай Зохицуулах зөвлөлийн даргын 2016 оны А/40 тоот тушаал	Энэхүү батлагдсан хүсэгтийн загвараар нийт ТЗЭ-чдийн үйл ажиллагааны хамрах хүрээг бүртгэж, хяналт тавина.



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

*Тэгш,
Чанартай,
Найдвартай,
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд*



ДҮГНЭЛТ



ҮР ДҮН

- Усны аюулгүй байдлыг хангах байдал дээшилсэн. Эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх шаардлагыг хэрэгжүүлсэн.
- ТЗЭ-ийн үйл ажиллагаанд мониторинг хийж үйлчилгээний чанарыг сайжруулах боломж бүрдсэн. /Бенчмаркинг, KPI/
- “Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан нь ТЗЭ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх, салбарын үйл ажиллагаа явуулах орчин нөхцлийг дээшлүүлэх зэрэг ач холбогдолтой юм.
- Салбарын хүний нөөцийг чадваржуулах ажлыг Яам болон олон улсын байгууллагуудтай хамтран хийж байна.
- Тоолууржилтын түвшин нэмэгдэн 2012 онд улсын дунджаар 63% байсан бол 2017 онд 84.5 хувь болж нэмэгджээ.



ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд салбарын хуулиудын уялдаа холбоог сайжруулах,
- УХАТ-ын салбарын зохицуулалтыг улам боловсронгуй болгох,
- Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зарим норм, дүрэм, стандарт шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулах, хамтран ажиллах
- Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах,



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

